**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 04 сарын 17 өдөр Дугаар А/63 Улаанбаатар хот

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 20 дугаар зүйлийн 20.1.9, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7, 19 дүгээр зүйлиний 19.3.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 33 дугаар зүйлийг тус тус үндэслэн Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх нь" сэдэвт зөвлөлгөөнийг 2017 оны 04 дүгээр сарын 24-ны өдөр Олон Улсын хүүхдийн Найрамдал төвд зохион байгуулах бэлтгэлийг сайтар хангаж ажиллахыг дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Н.Мөнхбаатар/-т даалгасугай.

2. Уг зөвлөлгөөний хөтөлбөрийг нэгдүгээр, зардлын тооцоог хоёрдугаар хавсралт ёсоор тус тус батлсугай.

3. Шаардагдах зардал 17.180.000 /арван долоон сая нэг зуун наян мянган / төгрөгийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны төсвийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас гаргахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нягтлан бодогч /М.Оюунсүрэн/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА М.МӨНХЦЭЦЭГ

11801 0187

Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн
2017... оны 04 дугаар сарын 17... -ны
өдрийн 11/33 дүгээр тогтоолын хавсралт

**"ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ" СЭДЭВТ ЗӨВЛӨЛГӨӨНИЙ ХӨТӨЛБӨР**

2017 оны 04-р сарын 12 Улаанбаатар хот

**Зорилго:**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх, зөвлөл, дэд зөвлөлийн ажлын уялдаа, холбоог сайжруулахад оршино.

**Хугацаа:**

2017 оны 04-р сарын 24-ны өдөр

**Хаана:** Олон Улсын Хүүхдийн Найрамдал төвд

**Зохион байгуулагчид:**

Сонгинохайрхан дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл

**Зөвлөлгөөнд оролцогчид:**

- Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар, Д.Тэрбишдагва, Д.Сумъяабазар, Б.Ундармаа, Ц.Гарамжав, Н.Учрал
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид Ц.Сандуй, С.Мөнхчулуун, Д.Баярсайхан, Б.Бямбадорж, Ц.Төрхүү, Б.Цолмон, Б.Отгонсүх, М.Халиунбат, Р.Дагва
- Сонгинохайрхан дүүргийн ИТХ-ын дарга Б.Мөнхцэцэг, Засаг дарга Ж.Сандагсүрэн, дүүргийн ИТХ-ын Төлөөлөгчид
- Сонгинохайрхан дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дарга, гишүүд
- Хороодын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөлийн дарга, гишүүд
- Хулгайн болон малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх дэд зөвлөлийн дарга, гишүүд
- Хүүхэд залуучуудыг осол эндэгдлээс, зөрчлөөс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн дарга, гишүүд
- Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн дарга, гишүүд
- Архидан согтуурах, хар тамхи мансууралтай тэмцэх дэд зөвөлийн дарга, гишүүд
- Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын дарга нар
- Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадын дарга нар

| № | Цаг | Арга хэмжээ |
|---|---|---|
| 1 | $13^{50}$-$14^{00}$ | Бүртгэл |
| 2 | $14^{00}$-$14^{05}$ | Нээлт /Төрийн дуулал/ |

| | | |
|---|---|---|
| 3 | $14^{05}$-$14^{15}$ | Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга бөгөөд дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дарга Б.Мөнхцэцэг нээж үг хэлнэ |
| 4 | $14^{15}$-$14^{20}$ | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга бөгөөд Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дарга Ц.Сандуй баяр хүргэж үг хэлнэ |
| 5 | $14^{20}$-$14^{40}$ | Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар<br>/Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын эрх зүйн орчин, шинэчлэлтийн талаар мэдээлэл/ |
| 6 | $14^{40}$-$14^{50}$ | СХД-ын ИТХ-ын дарга бөгөөд дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дарга Б.Мөнхцэцэг<br>/Сонгинохайрхан дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс зохион байгуулсан ажил, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл/ |
| 7 | $14^{50}$-$15^{00}$ | БГД, ХУД, СХД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын дарга Н.Чулуунжав<br>Шүүхээр 2016 онд таслан шийдвэрлэгдсэн, шүүн таслах ажиллагааны талаар мэдээлэл хийнэ |
| 8 | $15^{00}$-$15^{10}$ | Дүүргийн прокурор, Хууль цаазын итгэмжит зөвлөх Д.Отгонбаяр<br>/СХД дэх 2015, 2016 оны эрүүгийн нөхцөл байдлын харьцуулалт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар илтгэл/ |
| 9 | $15^{10}$-$15^{20}$ | Сонгинохайрхан дүүрэг дэх Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн дарга, Цагдаагийн хурандаа Ш.Цогбаатар<br>/2017 оны нэгдүгээр улирлын гэмт хэргийн нөхцөл байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр илтгэл/ |
| 10 | $15^{20}$-$15^{30}$ | Сонгинохайрхан дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтсийн дарга, Цагдаагийн хошууч Н.Ганбат<br>/Замын хөдөлгөөний аюулгүй байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар илтгэл/ |
| 11 | $15^{30}$-$15^{40}$ | Хорооны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөлийн тэргүүн туршлага илтгэл |
| $15^{40}$-$16^{00}$ | | Цайны завсарлага |
| 12 | $16^{00}$-$16^{05}$ | Зөвлөлгөөнөөс гарах зөвлөмжийн төсөл уншиж танилцуулах /хөтлөгч/ |
| 13 | $16^{05}$-$16^{45}$ | Зөвлөмжийн төсөлтэй холбоотой санал<br>/оролцогч бүр 3 минут/ |
| 14 | $16^{45}$-$16^{50}$ | Зөвлөлгөөнөөс гарах Зөвлөмжийг батлах |
| 15 | $16^{50}$-$17^{00}$ | Хаалтын үйл ажиллагаа |
| $17^{00}$-$18^{00}$ | | Оройн зоог |

Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн
2017......оны 02 дугаар сарын 17 өдрийн А/53
дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

# ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ СЭДЭВТ ЗӨВЛӨЛГӨӨНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

/Мянган төгрөгөөр/

| № | Зардлын нэр | Хэмжих нэгж | Тоо | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Засгийн газрын мэдээ сонины хавсралт /8 хуудас/ | ширхэг | 500 | - | 550,000 |
| 2 | Зөвлөмжийн эхийг бэлтгэж, дэвтэр болгон хэвлүүлэх | ширхэг | 1000 | 3500 | 3500,000 |
| 3 | Сэрэмжлүүлгийн эхийг бэлтгэж, ном болгох | ширхэг | 1000 | 3000 | 3000,000 |
| 4 | Бал | ширхэг | 40 | 3500 | 140,000 |
| 6 | | ширхэг | 380 | 900 | 342,000 |
| 4 | Тасалгаатай хавтас | ширхэг | 40 | 5800 | 232,000 |
| 5 | Кноптой хавтас | ширхэг | 380 | 1190 | 452,000 |
| 6 | Урилга | ширхэг | 1000 | 500 | 500,000 |
| 7 | Хоол, заалны түрээс | - | - | - | 7,180,000 |
| 8 | Хөтлөгч | | 1 | 300,000 | 300,000 |
| 9 | Унааны зардал | - | 6 | 200,000 | 924,000 |
| 10 | Балан дээр бичээс хийлгэх | | 40 | 1,500 | 60,000 |
| | Бүгд | | | | 17,180,000 |